

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ Барилга захиалагч" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: А.Гэрэлмаа

Утас: 99499667 Цахим хаяг: [infoaudit.selenge@gmail.com](mailto:infoaudit.selenge@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2023/04-НА-СТА-ОНА

**Товчилсон үгийн жагсаалт**

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

## Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	12
4. Аудитын тайлан .....	13
4.1. Ерөнхий зүйл .....	13
4.2. Материаллаг байдал.....	14
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.3.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
<b>4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>16</b>
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	16
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	17
5.1 Залруулга .....	17
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>17</b>



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ БАРИЛГА ЗАХИАЛАГЧ”  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Б.МӨНХБАТ ТАНАА

2023.03.15 № СЭА-2023/04-НА-СТА-ОНА

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ажил, үйлчилгээний нийт орлогыг 112,618.8 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 198,178.8 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 61.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлыг 43,018.8 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 26,091.4 мянган төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөг 16,927.4 мянган төгрөгөөр хэмнэж, 112,098.5 мянган төгрөгийн ашигтай тайлагнагдсан байна.

### Аудитын гол асуудал

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь гүйцэтгэлээр 198,178.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 79,693.8 мянган төгрөгийн зардал тайлагнагдсан ба

нийт зардлын 59.4 хувийн цалингийн зардал, 7.8 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 12.1 хувийг шатахууны зардал, 4.9 хувийг албан томилолтын зардал, 3.1 хувийг бичиг хэргийн зардал эзэлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2022	12/31/2022
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	126,535,617.86	226,444,279.29
1.1.2	Дансны авлага	11,330,080.56	18,657,365.56
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	354,892.41	
1.1.6	Бараа материал	3,194,456.85	3,194,456.85
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>141,415,047.68</b>	<b>248,296,101.70</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,901,743.42	28,927,365.82
1.2.2	Биет бус хөрөнгө		
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>4,901,743.42</b>	<b>28,927,365.82</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>146,316,791.10</b>	<b>277,223,467.52</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1.1	Дансны өглөг		4,878,472.99
2.1.1.2	Цалингийн өглөг	1.18	
2.1.1.3	Татварын өр	158,521.00	14,021,724.17
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>158,522.18</b>	<b>18,900,197.16</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>158,522.18</b>	<b>18,900,197.16</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.01	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	146,158,268.91	258,323,270.36
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>146,158,268.92</b>	<b>258,323,270.36</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>146,316,791.10</b>	<b>277,223,467.52</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	123,955,810.00	198,146,974.55
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>123,955,810.00</b>	<b>198,146,974.55</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		31,818.18
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	68,103,670.63	79,693,851.64
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	446,136.36	5,201,573.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>55,406,003.01</b>	<b>113,283,368.09</b>
19	Орлогын татварын зардал	558,521.00	1,184,849.41
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>54,847,482.01</b>	<b>112,098,518.68</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>54,847,482.01</b>	<b>112,098,518.68</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>54,847,482.01</b>	<b>112,098,518.68</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		-			91,310,786.91	91,310,786.91
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-	-
3	Залруулсан үлдэгдэл						-
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)					54,847,482.00	54,847,482.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт						-
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
9	2021 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	146,158,268.91	146,158,268.91
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					66,482.77	66,482.77
11	Залруулсан үлдэгдэл						-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					112,098,518.68	112,098,518.68
13	Бусад дэлгэрэнгүй орлого						-
14	Өмчид гарсан өөрчлөлт						-
15	Зарласан ногдол ашиг						-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
17	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	-	-	-	-	258,323,270.36	258,323,270.36

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>133,439,719.00</b>	<b>211,623,244.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	133,439,719.00	210,636,387.00
1.1.2	Бусад мөнгөн орлого		986,857.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>78,302,484.49</b>	<b>80,252,682.57</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	36,443,969.00	42,325,582.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,504,093.62	11,674,722.76
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,808,496.00	3,944,850.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	514,800.00	1,714,800.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,218,128.50	10,835,050.00
1.2.6	Даатгалын төлбөрт төлсөн	74,250.00	74,250.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	14,930,297.37	5,933,470.81
1.2.8	Бусад мөнгөн зарлага	3,808,450.00	3,749,957.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>55,137,234.51</b>	<b>131,370,561.43</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	<b>31,461,900.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		31,461,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>(31,461,900.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>55,137,234.51</b>	<b>99,908,661.43</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>71,398,383.35</b>	<b>126,535,617.86</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>126,535,617.86</b>	<b>226,444,279.29</b>

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Төсөв /төгрөгөөр/	Гүйцэтгэл /төгрөгөөр/	Зөрүү	Хувь
1	<b>Нийт орлого /НӨАТ-гүй/</b>	<b>122,618,850.00</b>	<b>198,178,792.73</b>	75,559,942.73	<b>0.62</b>
2	<b>Нийт зарлагын дүн</b>	<b>116,118,850.00</b>	<b>79,693,851.64</b>	<b>-36,424,998.36</b>	<b>(0.31)</b>
	<b>Цалин хөлс</b>	<b>65,000,000.00</b>	<b>47,375,928.00</b>	<b>-17,624,072.00</b>	<b>(0.27)</b>
3	Үндсэн цалин	62,000,000.00	47,375,928.00	-14,624,072.00	(0.24)
	Урамшуулал	3,000,000.00		-3,000,000.00	(1.00)
4	<b>НДШ-ийн зардал</b>	<b>8,100,000.00</b>	<b>6,226,491.32</b>	<b>-1,873,508.68</b>	<b>(0.23)</b>
	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>43,018,850.00</b>	<b>26,091,432.32</b>	<b>-16,927,417.68</b>	<b>(0.39)</b>
	Программ хангамжийн зардал	1,000,000.00	230,000.00	-770,000.00	(0.77)
	Түлш шатахуун	12,800,000.00	9,645,500.00	-3,154,500.00	(0.25)
	Албан томилолт	5,000,000.00	3,931,072.73	-1,068,927.27	(0.21)
	Сэлбэг хэрэгсэл	3,300,000.00	1,095,000.00	-2,205,000.00	(0.67)
	Шуудан холбоо	1,000,000.00	468,000.00	-532,000.00	(0.53)
	Бичиг хэрэг	6,718,850.00	2,510,000.47	-4,208,849.53	(0.63)
	Сургалт	3,000,000.00	675,000.00	-2,325,000.00	(0.78)
5	Нэг удаагийн тэтгэмж	1,500,000.00		-1,500,000.00	(1.00)
	Түрээсийн зардал	1,000,000.00	1,200,000.00	200,000.00	0.20
	Даатгалын зардал	100,000.00	74,250.00	-25,750.00	(0.26)
	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	71,532.00	-28,468.00	(0.28)
	Эд хогшил, тоног төхөөрөмж	4,500,000.00	357,135.89	-4,142,864.11	(0.92)
	Үйл ажиллагааны бусад зардал	3,000,000.00	5,833,941.23	2,833,941.23	0.94
	<b>Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>6,500,000.00</b>	<b>5,201,573.00</b>	<b>-1,298,427.00</b>	<b>(0.20)</b>
	Үйл ажиллагааны бус бусад зардал	1,500,000.00	355,100.01	-1,144,899.99	(0.76)
	Аймгийн ЗДТГ-т гэрээний дагуу	5,000,000.00	4,846,472.99	-153,527.01	(0.03)
6	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал</b>	<b>6,500,000.00</b>	<b>118,484,941.09</b>	<b>111,984,941.09</b>	<b>17.23</b>
7	Орлогын албан татвар	0.00	1,184,849.41	1,184,849.41	
8	<b>Татварын дараахь ашиг, алдагдал</b>	<b>-</b>	<b>112,098,518.68</b>	<b>112,098,518.68</b>	
	<b>Нийт ажиллагсдын тоо</b>	<b>6</b>	<b>6</b>		
	Удирдах ажилтан	1	1		
9	Гүйцэтгэх ажилтан	1	1		
	ИТА	3	3		
	Гэрээт инженер	1	1		
10	Байгууллагад авто машин худалдаж авах	30,000,000.00	30,000,000.00	-	

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь *“Улсын болон аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хийгдэж буй барилга угсралт, шинэчлэлт, засвар тохижилтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх”* гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтээн байгуулалт, барилгын ажлын төсөв, санхүүг зөв зохистой төлөвлөн зарцуулах,
- Улсын болон орон нутгийн төсвийн, хувийн хөрөнгө оруулалт, төрийн оролцоотой хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэх барилга, зам, инженерийн шугам сүлжээний угсралт, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах, зураг төсөл зохиох ажлын захиалагчийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга байх бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2014 оны 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д *“Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”,* 21 дүгээр зүйл *“Аймгийн чиг үүрэг”,* 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь *“аймгийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт”,* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2: *“Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”* гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	126,535.62	226,444.28	99,908.66
Авлага	11,330.08	18,657.37	7,327.29
Татвар, НДШ-ийн авлага	354.89	0.00	(354.89)
Бусад авлага			-
Бараа материал	3,194.46	3,194.46	-
Үндсэн хөрөнгө	4,901.74	28,927.37	24,025.62
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>146,316.79</b>	<b>277,223.47</b>	<b>130,906.68</b>
Өр төлбөр	158.52	18,930.20	(18,771.68)
Эздийн өмч	146,158.27	258,293.27	112,135.00
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>146,316.79</b>	<b>277,223.47</b>	<b>130,906.68</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 99,908.7 мянган төгрөгөөр өссөн нь 213,393.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 113,484.5 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 18,657.4 мянган төгрөг болж 7,327.3 мянган төгрөгөөр өссөн нь Цагааннуур сумын төвийн хатуу хучилттай замын 3,124.4 мянган төгрөгийн, Жавхлант сумын малын худаг шинээр барих ажлын захиалагчийн хяналтын 1,503.1 мянган төгрөг зэргээр авлага буурсан болон тайлант онд дууссан боловч улсын комисст хүлээлгэж өгөөгүй байгаа дараах ажлуудын захиалагчийн хяналтын авлага нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Баруунбүрэн сумын төрийн албан хаагчийн 4 айлын орон сууцны 3,716.7 мянган төгрөгийн,
- Цагааннуур сумын төвийн хатуу хучилттай 2.53 км замын 1,242.9 мянган төгрөгийн,
- Цагааннуур сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн 427.9 мянган төгрөгийн,
- Түшиг сумын ЭМТ-ийн их засварын ажлын 3,635.5 мянган төгрөгийн,
- Сүхбаатар сумын 7-р багийн камержуулалтын 1,087.5 мянган төгрөгийн,
- Орхонтуул сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажлын захиалагчийн хяналтын 538.7 мянган төгрөгийн,
- Орхонтуул сумын Рашаант тосгоны зам засвар, тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажлын 630.7 мянган төгрөгийн,
- Түшиг сумын зам засвар, тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажлын 672.8 мянган төгрөгийн зэрэг.

Татвар НДШ-ийн авлага 354.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны НӨАТ-ын өглөг суутгагдсанаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,194.5 мянган төгрөг байгаа нь хангамжийн материалын үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 28,626.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 27,272.7 мянган төгрөгийн Toyota Voxy маркийн суудлын автомашин, 781.7 мянган төгрөгийн принтер, 270.0 мянган төгрөгийн тень, 301.8 мянган төгрөгийн автомат баримт үдэгч худалдан авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 18,930.2 мянган төгрөг болж 18,771.7 мянган төгрөгөөр өссөн нь Сэлэнгэ аймгийн ЗДТГ-т өгөх 4,846.5 мянган төгрөгийн, НӨАТ-ын 12,807.3 мянган төгрөгийн, орлогын албан татварын 1,184.8 мянган төгрөгийн зэрэг өр төлбөрүүд шинээр үүссэнээс голлон шалтгаалжээ.

Хуримтлагдсан ашиг 112,135.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашигтай холбоотой байна.

### **3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг Сэлэнгэ аймгийн Засаг дарга баталсан бөгөөд 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 122,618.8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 122,618.8 мянган төгрөгөөр тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын 1 арга хэмжээнд 30,000.0 мянган төгрөг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 198,178.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 79,693.8 мянган төгрөгийн зардал гарган, 112,098.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 198,178.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 75,560.0 мянган төгрөг буюу 61.6 хувиар давж биелсэн нь аймгийн болон сумдын орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг болон барилгын гүйцэтгэлд гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналтыг гүйцэтгэснээс голлон шалтгаалсан байна

Нийт зардлын гүйцэтгэл 79,693.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 42,925.0 мянган төгрөг буюу 35.0 хувиар хэмнэгдсэн нь цалин хөлс, шатахуун, албан томилолт, сэлбэг хэрэгслийн зардлуудын хэмнэлтээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 112,098.5 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь нийт орлогыг 61.6 хувиар давуулан биелүүлж, зардлыг 35.0 хувиар хэмнэснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

## **4. Аудитын тайлан**

### **4.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын аудитор А.Гэрэлмаа гүйцэтгэж,

хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 123,955.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,239.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.3.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 20 төрлийн 148 мэдээллээс 73 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн боловч бүрэн хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбартай холбоотой мэдээллийг 7 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,

- Дараа жилийн төсвийн төсөлтэй холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлантай холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээтэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 7 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягтай холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлтэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлантай холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлттэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлттэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнтэй холбоотой мэдээллийг 6 удаа гэх мэт.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/634 дүгээр албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд үйлдвэрлэлийн үр дүнгээр өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжийг хэрэгжүүлэн алдагдалгүй ашигтай ажиллах бүхий л бололцоог ханган ажиллах, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

”Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Борлуулалтын орлогыг 74,222.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр НӨАТ 7,422.3 мянган төгрөгөөр, орлогын татварын зардал 626.3 мянган төгрөгөөр өсөж, төсөвт шилжүүлсэн.
- Үйл ажиллагааны үр дүнгээр 112,098.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх тайлант үеэс 57,251.0 мянган төгрөгөөр буюу 2.0 дахин давж биелсэн байна.

#### **4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын 2022 оны 11 дүгээр 02-ны өдрийн 22/54 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 430.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримттай холбоотой алдаа зөрчилд өгөгдсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага					
Зөвлөмж	1	430.0	1	430.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>430.0</b>	<b>1</b>	<b>430.0</b>	<b>100.0</b>

#### 4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. Аудитын илрүүлэлт

#### 5.1 Залруулга

Аудитаар нийт 47,994.3 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд 11,952.7 мянган төгрөгийн борлуулалтын авлагыг тайлагнаагүй,
- Өр төлбөр дансны үлдэгдлийг 858.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд тайлант оны орлогыг 10,866.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Цалингийн журналд ХХОАТ-ын хөнгөлөлтийг 32.0 мянган төгрөгөөр илүү, 2.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- ААНОАТ-ын тайланд 10,897.9 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан,
- НӨАТ-ын тайланд 12,384.9 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан,
- ХХОАТ-ын тайланд цалингийн зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан гэх мэт.

Аудитаар зөрчил илрээгүй болно.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланд	1	11,952.7	1	11,952.7			1	11,952.7				

**“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит**

борлуулалтын авлага тайлагнаагүй													
Өр төлбөр дансны үлдэгдлийг дутуу тайлагнасан	1	858.7			1	858.7	1	858.7					
Орлогыг дутуу тайлагнасан	1	10,866.1			1	10,866.1	1	10,866.1					
Цалингийн журналд ХХОАТ-н хөнгөлөлтийг зөрүүтэй тайлагнасан.	1	34.0			1	34.0	1	34.0					
ААНОАТ-ын тайланд орлого илүү тайлагнасан	1	10,897.9			1	10,897.9	1	10,897.9					
НӨАТ-ын тайланд орлого дутуу тайлагнасан	1	12,384.9			1	12,384.9	1	12,384.9					
ХХОАТ-ын тайланд цалингийн зардлыг дутуу тайлагнасан	1	1,000.0			1	1,000.0	1	1,000.0					
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>47,994.3</b>	<b>1</b>	<b>11,952.7</b>	<b>5</b>	<b>36,041.6</b>	<b>6</b>	<b>47,994.3</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Дүн</b>													

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	73				73			
Огт мэдээлээгүй								
<b>Дүн</b>	<b>73</b>				<b>73</b>			
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>73</b>				<b>73</b>			